



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар Ажлын

Арвайхээр сум

Улсыг үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах улсын үзлэгийг боловсролын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг хамруулан зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Улсын үзлэгийг сайтар зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, тайланг нэгтгэн, танилцуулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0570

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын ..... -ны өдрийн ..... дугаар  
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:  
Б.Бүзмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Н.Мөнгөншагай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Б.Батчулуун (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Б.Дашдэмбэрэл (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

М.Одхүү (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн эруул ахуй хяналтын улсын байцаагч)

О.Гансүх (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн)

Ц.Баяrbat (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Доржпүрэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эруул ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

-оOo-